

СОЛОНГОСЫН ДАЙНЫ ТАЛААРХИ ОХУ-ЫН ШИНЭ БАРИМТУУД

*Д.Уламбаяр**

1995 оноос Вашингтон дахь Вудро Вильсоны Олон улсын судалгааны Төв “Хүйтэн дайны үеийн олон улсын харилцааны түүх” олон улсын томоохон төслийг хэрэгжүүлж, “Ази дахь хүйтэн дайн” дэд төслийн судалгааны эхний үр дүнд Солонгосын дайны, Зөвлөлт-Хятадын харилцаа, Вьетнамын дайны түүхийн олон бүрхэг асуудлууд тодорхой болж ирсэн юм.

Оросын ерөнхийлөгч Б.Ельцинийн 1994 оны 6 дугаар сард Өмнөд Солонгосын ерөнхийлөгч Ким Ён-самд өргөн барьсан Солонгосын дайны талаарх дээд хэмжээний баримт материал төслийн чухал хэсэг болсон бөгөөд тэрхүү нийтлэгдсэн эмхтгэлийн хэсгээс энд авч үзэв. Мөн 1950 оны 6 дугаар сарын 25-нд эхэлсэн дайн хийх шийдвэр гаргах шалтгааныг тайлбарласан тэрхүү цуглуулагын 6 гол баримтыг Катрин Веадерсбайн орчуулгаар ашиглав. 1995 онд Хавар нэртэй Богино Мэдээлэл гарснаас хойш Солонгосын дайны тухай баримт нотолгоонууд нь Москва дахь Ерөнхийлөгчийн Архиваас гаргасан ойролцоогоор 1200 хуудастай уг дайны талаарх дээд хэмжээний нууц байсан бүрэн бүтэн баримтыг олонд эл болгосон нь Солонгосын дайны нууц түүхийг улам бүр баяжуулж байна. Колумбын их сургуулийн Солонгос судлалын төв болон хүйтэн дайны олон улсын төсөл хоёрын судалгааны ажил нь эдгээр баримтуудыг үзэж судлах сонирхолтой бүх судлаачдын анхаарлыг татаж, мөн ч олон нийтийн хүртээл болгож байгаа юм.

Ерөнхийлөгчийн Архив (албан ёсны нэр нь ОХУ-ын Ерөнхийлөгчийн архив-ОХУЕА) гэдэг нь ЗХУ-ын үед мэдээлэл хадгалах хамгийн чухал (ЗХУКН-ын ТХ-ны УТТ) газар байсан бөгөөд Кремлийн удирдлагууд аюул авчирч болзошгүй, ашиглах боломжгүй маш нууц мэдээллүүдийг тийш нь хийдэг байжээ. Тиймээс энэ архивын боловсон хүчин, мэргэжилтнүүдийг ЗХУКН-ын ТХ, ЗХУ-ын ГЯЯ, болон Зөвлөлтийн ЗХЖШ-ын архивт хүмүүсийг шалгаж авдгаас илүү их нарийн сонгон шалгаруулалтайгаар томилдог байжээ. Харин бусад гол архивуудыг хүйтэн дайны үеийн түүхчид “зохих хэмжээнд” ашигладаг байсан юм. Солонгосын дайны талаарх ОХУЕА-аас гаргасан асар их баримтууд нь Их зөрчилийн үе дэх дээд шатны шийдвэрүүд болон коммунистуудын хэлэлцүүлгүүдийн тухай үнэтэй нотолгоо болж байна.

Одоогийн эдгээр эх нь 1990-ээд онд ил болсон ОХУЕА-ын Солонгосын дайны талаарх баримт материалын тухай юм. Ил болсон баримтуудын ихэнх нь 1950 оны 2 дугаар сараас 1951 оны 2 дугаар сарыг хамарч байгаа ба Их зөрчлийн эхний эгзэгтэй саруудад ЗХУ

* Д.Уламбаяр - доктор (Ph.D)

Солонгосын дайнд гүйцэтгэсэн үүргийг сайн харуулахаас энэ эх сурвалж эхэлж байгаа юм. Тиймээс 1950 оны хавраас дайн төгсөх үе хүртэлх баримтуудаас хамгийн сонгомол дээжийг эхний ээлжинд нийтэлсэн бөгөөд юун түрүүнд Сталин энхийн гэрээ хэлэлцээрүүдэд яаж оролцож байсныг харуулж байна. Зөвлөлт Засгийн газрын шийдвэр гаргаж байсан байдал, Москва-Бээжин-Пёнъяны гурвалжин, Солонгосын дайны талаарх ямар олон асуудлыг шийдвэрлэж байсан, Хятад, ЗХУ, Хойд Солонгосын харилцаа, АНУ руу хандах Зөвлөлтийн чиг хандлага, Сталины амьдралын сүүлчийн жилүүдийн Зөвлөлтийн гадаад бодлогыг ерөнхийд нь дүр зургийг үзүүлж байгаа ажээ. Энд шинэ гарсан эх сурвалжуудын өгч буй хамгийн чухал мэдээллүүдийн заримыг нь өгүүлж, үндсэн нэмэлт мэдээллээс зарим нэг урьдчилсан дүгнэлт хийхийг зорив.

Өөрөөр хэлбэл Сталин 1950 оны 1 дүгээр сарын 30-нд Пёнъянд суугаа Зөвлөлтийн элчин сайдад илгээсэн цахилгаан, Ким Ил-сон (Ким Ир Сен)-д хандан Солонгосыг цэрэг, дайны хүчээр нэгтгэх үйл хэрэгт тусламж дэмжлэг үзүүлэх болно гэсэн хэсгүүд байгаа юм.

Баримт 1. Сталины зурвасыг Ким Ил-сонь болон Зөвлөлтийн элчин сайд Т.Ф.Штыков нар Өмнөд Солонгосын эсрэг хүч хэрэглэх ажиллагааг төлөвлөхийг зөвшөөрлөө гэж ойлгосон ажээ. Хойд Солонгосын тэргүүн Сталины цахилгаан утсыг “маш баяртай” хүлээж аваад, ажиллагаагаа явуулахын тулд Сталинтай уулзаж ээлтгэл ажлаа эхлэхээ Штыковд мэдэгджээ. Штыковт 2 дугаар сарын 2-нд Батлан хамгаалахын сайд А.М.Васильевскийн илгээсэн мэдээнд: БНАСАУ-ын цэргийнхний саналыг дэмжиж байгаагаа илэрхийлэн Ким Ил-соны 4 дүгээр сард Москвад хийх айлчлалаас ч өмнө Хойд Солонгосын цэргийн хүчийг бэхжүүлэхээр Сталин арга хэмжээ авч эхлэх бөгөөд Зөвлөлтийн Жанжин Штабын Дайны туршлагыг судлах шинжээчдийн хэсгийн дарга ЗХУ-ын баатар, дэслэгч генерал Василевийг Солонгост суух элчин сайдын албанд томилж, Сталин өөрөө Солонгосын Ардын Армийн хариуцлагатай зөвлөхөөр ажиллах болсныг мэдэгджээ.

Баримт 2. Штыковын 2 дугаар сарын 7-нд ГЯЯ-ын сайд Андрей Вышинскийд илгээсэн цахилгаанаас үзэхэд БНАСАУ зээл авах, цэргийн нэмэлт 3 дугаар дивиз байгуулах, Ардын Дээд хурал хуралдуулах, ЗХУ руу сүлжмэлийн ажилчдыг сургалтад явуулах зэрэг Хойд Солонгосын шийдвэрлэх асуудалд Сталин ойроос удирдан хянаж буйг тодорхой харж болно.

Баримт 5-9, Үндсэрхэх үзэлтэй Солонгосын коммунистууд яагаад улсынхаа хэрэгт энэ мэтийн хөндлөнгийн оролцоог зөвшөөрсөн шалтгааныг мөн тайлбарлажээ. Хойд Солонгос нь бараа бүтээгдэхүүний хувьд ЗХУ-аас асар их хамааралтай, хуучин Японы эзэнт гүрний ноёрхлоос ангижраад удаагүй байсан “эзэнгүй” оронд шинэ социалист төрийг цогцлон байгуулахад маш их чадвар шаардагдаж байжээ.

1945-1950 онд БНАСАУ-ийн хувьд дэмжлэг хүсэн царайчлах орон нь ЗХУ байлаа. Хойд Солонгосын удирдагчид ХКН-тай дотно харилцаатай боловч, тэд Солонгос нөхдүүддээ туслах хэмжээнд байгаагүй юм. 1950-иад оны эхэн үед Мао Зедуны тэргүүлсэн Бээжингийн Засгийн газар өөрсдөө эдийн засаг, цэргийн тусламж дэмжлэг авахаас өөр аргагүй байв.

Баримт-11, 13, 1950 оны хавар Мао Зедун болон Ким Ил-сонь хоёр ЗХУ болон БНАСАУ хоёрын хооронд худалдаа, эдийн харилцаа холбоог илүү өргөн хөгжүүлэх боломжийг сонирхож байсан ажээ. Пёнъян, Бээжин хоёрын эдийн засаг, цэргийн ойр харилцаа Солонгосын дайнд Хятад улс оролцсоноор эрчимтэй хөгжиж эхэлжээ. Гэхдээ 1950 оны 1 дүгээр сарын эхэн хүртэл хятадууд ямар нэг үйл явдалд оролцоогүй байна.

4 дүгээр сард Москвад дээд хэмжээнд болсон нууц айлчлалын үеэр Өмнөд Солонгосын эсрэг дайн эхлэх нууц зөвшөөрлийг Зөвлөлтийн тэргүүнээс хүлээж авсаны дараа, Сталины шаардлагаар Ким Ил-сонь 1950 оны 5 дугаар сард Мао Зедунээс дайралт хийх зөвшөөрөл дэмжлэг авахаар Бээжинг зорьжээ. Мао Зедун Ким Ил-соньтай хэлэлцэж байхдаа АНУ-тай томоохон зөрчилдөөн үүсэх боломжийн талаар нэг их санаа зовоогүй байсан ба “Америкчууд ийм жижигхэн газар нутгийн төлөө дэлхийн III дайн хийхгүй биз” гэж хэлж байжээ. 1950 оны 5 дугаар сард Ким Ил-сонь Зөвлөлтийн алсдаа Хойд Солонгост үзүүлж болох дарамтаас сэргийлж стратегийн тодорхой алхам хийж хожим нь Хятад, ЗХУ хоёр бие биеийнхээ эсрэг тоглоход маш сайн ашигласан ажээ. Ким Зөвлөлтийн Элчин сайд Штыковд анхандаа Мао Зедунаас ойрмогхон Хятадаас Хойд Солонгос руу дамжин өнгөрөх Солонгос цэргүүдэд зэвсгийн хангамж хүсэх гэж байсан боловч Солонгосын ардын арми хангалттай зэвсгийн нөөц байгааг түүнд хэлсний дараа тэр асуудлыг огт хөндөж тавихгүй байхаар шийдсэн гэж илтгэжээ. Түүнчлэн, түүний бүх хүсэлтийг Москва нааштай хүлээж авч, шаардлагатай, хангалттай тусламж авахаас хойш Мао Зедунээс хүсэх өөр гуйлт байхгүй гэж тэрээр хэлжээ.

Штыков, Вышинскийд илгээсэн 5 дугаар сарын 12-ны мэдээндээ, Пёнъянаас Бээжин явах өдрийн өмнөх өдөр Ким Ил-сонь Өмнөд Солонгосын эсрэг хүчээр цэргийн ажиллагаанд бэлтгэхийг Жанжин штабын даргадаа тушаасан бөгөөд хэдийгээр тухайн үед тэд бэлэн байх, үгүйг мэдэхгүй ч гэсэн 6 дугаар сард уг ажиллагааг эхлэнэ гэдгээ өөрт нь мэдэгдсэн гэжээ. Харамсалтай нь 1950 оны 4-6 дугаар сарын эгзэгтэй чухал үеийн зарим баримт материалууд Москва дахь Ерөнхийлөгчийн Архивд бага, тэдгээр тоо баримтыг ойрын ирээдүйд нээх ажээ. Тиймээс Хойд Солонгос дайралтаа яаж төлөвлөсөн тухай маш олон асуулт тодорхой биш хэвээр үлдсэн. Гэсэн хэдий ч, Британий ВВС-гийн баримтат киноны баг 1994 онд Солонгосын дайны талаар хийсэн судалгааны

ажлаараа дайралтын бэлтгэл болон ажиллагааны эхний өдрийн талаарх нууцыг ил тод болгосон байна. Хойд Солонгост илгээгдсэн Зөвлөлтийн цэргийн онцгой даалгаварын тэргүүн Василевт Штыковын бичиж илтгээсэн тайланд 6 дугаар сарын 12-23-нд цэргүүд Жанжин Штабын төлөвлсөний дагуу онцгой байдалд байсан ба Зөвлөлтийн зөвлөгчид онгоцоор тагнах ажиллагаа болон дивизийн хэмжээнд ажиллагааг төлөвлөхөд оролцсон гэжээ. Гэсэн ч Зөвлөлтийн зөвлөхүүдийг дайралт эхлэхээс өмнө тэргүүн шугамаас буцаасан нь ажиллагааны үр дүнд сөргөөр нөлөөлсөн байна. Энэ нь эцсийн мөчид Сталин цэргүүд нь баривчлагдан хоригдож магад, тэгвэл энэ ажиллагаанд Зөвлөлт оролцсон нь мэдэгдэнэ гэдгээс айн цэрвэж Зөвлөлтийн зөвлөхүүдийг тэргүүн шугамаас буцаан татсан гэдэг Н.С.Хрушевийн дурсамжтай таарч байгаа юм.

Зөвлөлтийн зөвлөхүүдээ буцаан татвал яах бол гэдэг асуултыг 6 дугаар сарын 1-нд Сталин Штыковд тавьж байсан байна. Энэ нь Сталин Солонгосын дайнд Америк оролцвол Солонгосын байдал ямар болох бол гэхээс түгшиж байсныг харуулж байна. Хэрэг дээрээ, Солонгосын байдал Зөвлөлтийн цэргүүдийг Америкийн зэвсэгт хүчинтэй тулалдуулах вий гэсэн бодол Зөвлөлтийн тэргүүнийг зовоож байсан ба Штыков ч асуултад нь маш няхуур хариулж байжээ. Штыков Ким Ил-сонь болон Хойд Солонгосын Ерөнхий сайдын орлогч бөгөөд ГЯЯ-ны сайд Пак Хон-ёнъ хоёрт “Энэ дайнд Америк оролцсоноор бий болох хүндэрлийг ойлгож байна, тэгээд ч хүн хүч, материаллаг нөөцийг тогтоох шаардлагатай арга хэмжээ авч байна” гэж мэдэгдсэн боловч БНАСАУ-ийн удирдлагын зарим хүмүүс энэ дайнд Зөвлөлтийг эл тодоор оролцохыг гуйж байжээ. Сталин зөрчлийг үргэлжлүүлэхүйц Солонгосын дайны стратеги явуулсныг 6 дугаар сарын эхний долоо хоногоос харж болохоор байна. Тэрбээр Зөвлөлтийн цэргүүдийг Америкчуудтай байлдахаас зайлуулах гэж Хятадын удирдлагыг энэ дайнд оролцож байлдаанд БНАСАУ-ын ялагдахаас хамгаалахыг шаардсан байна.

1994 онд Колумбын Их сургуулиас эрхлэн Хятадын судлаач Чен Жиян бичсэн “Солонгосын дайнд оролцсон Хятадын зам: Хятад-Америкийн зөрчилдөөнийн эхлэл тавигдсан нь” бүтээлд Хятадын удирдлага Хойд Солонгосын хил рүү орж ирж болзошгүй байдлаас хамгаалахаар дөнгөж 6 дугаар сарын 7-10-нд цэргүүдээ Солонгосын хилийн ойролцоо илгээсэн ба Солонгос руу цэрэг илгээх явдал 10 дугаар сарын эхэн үед Өмнөд Солонгост НҮБ тусламж үзүүлэх хүртэл үргэлжилж байжээ. Сталин Бээжин дэх Зөвлөлтийн элчин сайддаа илгээсэн мэдээндээ 6 дугаар сарын дунд болох уулзалтуудаас өмнө Бээжингийн удирдлагууд Сталинд амласан цэргээ оруулах асуудлаар хэлэлцэж байсан байна. Сталин Хятадын ГЯЯ-ны сайд Жоу Эньлайд 7 дугаар сарын 5-нд Төлөвлөгөөг зөвшөөрч байгаагаа болон Хятадын цэргүүдийг нисэх онгоцоор хангахаа амласан байна.

6 дугаар сарын 8-нд Мао Зедунд илгээсэн Сталины дээрэнгүй мэдээ нь уг дайнд хятадууд оролцоход хүчтэй түлхэц болсон байна. Сталин 6 дугаар сарын 13-нд Мао Зедунд илүү их хүйтэн зэвүүн үгтэй мэдээ илгээсэн байх бөгөөд үүнд Солонгосын хил рүү Хятадууд цэргээ илгээхээр шийдсэн эсэх талаар одоо болтол мэдээ аваагүй байна гэж бухимдаж, нисэх онгоцоор туслана хангана гэдгээ дахин илэрхийлжээ. Мөн түүнчлэн тэрбээр Хятадын нисгэгчдийг 2, 3 сарын дотор сургах гэж байгаа бөгөөд Солонгосын дайнд шаардлагатай тоног төхөөрөмжийг нисгэгчидтэй нь хамт явуулна гэж мэдэгджээ.

Баримт -26, БНХАУ-ын ГЯЯ-ны сайд Жоу Эньлайд 8 дугаар сарын 27-нд Сталин, Хятад руу 38 нисэх онгоц, агаараас хамгаалах хүчний мэргэжилтнүүдээ илгээнэ гэж мэдэгдсэн байна. Тэдгээр зөвлөх, тэдэнтэй хамт ирсэн асар олон тооны тоног төхөөрөмж, зэвсэг техник нь БНХАУ-ын агаарын хүчинг байгуулах ЗХУ-аас үзүүлсэн аугаа их дэмжлэг болсон бөгөөд энэ их үйл явц Солонгосын дайны жилүүдэд үргэлжилсээр байжээ.

1950 оны 8 дугаар сарын 28-нд Сталины Ким Ил-сонд илгээсэн зурвас нь Америк улс Солонгосын дайнд оролцсоноор бий болсон хүнд хэцүү байдалд Зөвлөлтийн тэргүүн ямар байр суурьтай байсныг харуулж байна. Хойд Солонгос Америкийн агаарын довтолгоонд хүчтэй нэрвэгдэж байх үед Сталин Ким Ил-соныг 1918-1922 оны Орос орны иргэний дайн, 1940-1945 оны гитлерийн Германтай хийсэн эх орны дайны үед Улаан Арми ямар их зоригтой байснаас үлгэр жишээ авах ёстой хэмээн ятган зоригжуулж байжээ. Тэрбээр Хойд Солонгосын жижигхэн агаарын хүчинд нэмэлт нисэх онгоц явуулахыг санал болгосон ч Зөвлөлтийн нисэх хүчин, хуурай замын цэргийн хүчинг илгээхийг санал болгож байгаагүй ажээ. АНУ-ын цэргийн хүчинтэй халз тулгарахаас зайлсхийх нь Зөвлөлтийн тэргүүний сайн мэдэх зүйл байжээ.

Хятадын цэргийн хүчийг Солонгосын дайнд оруулах талаарх 1950 оны 10 дугаар сард Хятадын удирдлагатай хийсэн Сталины хүндхэн, бас гайхамшигтай хэлэлцээрүүд нь Александр Мансуровын энэ талаар бичсэн өгүүлүүдэд тодорхой байгаа юм. Хятад энэ дайнд яаж оролцож байсан, тэр дундаа ХАЧА цэрэг илгээж байсан, ЗСБНХУ-ын хангамж болон зөвлөхүүдэд Хятад улс төлбөр төлж байсан бөгөөд Хятадын оролцоо нь тэдний удирдлагын төвшинд ширүүн маргаан болж үргэлжилсэн байна. Энхийн хэлэлцээрүүд явуулах Сталины арга болон Солонгосын дайны үед Хятад руу цэргийн хангамж илгээн тус улсаас хугацаа тооцон өндөр төлбөр шаардаж байсан нь эцэстээ Зөвлөлт-Хятадын найрамдлын холбоог задран унагахад чухал нөлөө үзүүлсэн ажээ.

Баримт 31, 1950 оны 10 дугаар сарын сүүлчээр болсон хэрэг явдлыг сэргээвэл, 1950 оны 10 дугаар сарын 25-нд ЗХУКН-ын ТХ-ны УГТ-ны шийдвэрээс үзэхэд Зөвлөлтийн удирдлага АНУ Солонгосын дайныг ашиглан Японыг дахин зэвсэгжүүлж магадгүй гэж санаа зовж

байжээ. Сталин Япон улс дахин хүчтэй болох вий хэмээн түгшсээр байсан байна. 1947 онд АНУ-ын цэрэг Зөвлөлтийн Номхон далайн эрэг хавийн хил дагуух Японы хүчийг бэхжүүлэхээр дахин зэвсгээр хангаж байсан боловч тэр нь Алс Дорнодын Комисстой тулгарч бүтэлгүйтсэн байна. Түүнчлэн Өмнөд Солонгост хийсэн Хойд Солонгосын цохилтоос 2 долоо хоногийн дараа АНУ-ын генерал Дуглас МакАртур, Японы ерөнхий сайдад 75000 хүнтэй “Үндэсний цэргийн нөөцтэй” болохыг тушаасан байх бөгөөд үнэндээ тэдгээрийн зарим хэсэг нь Солонгост илгээгдсэн байна.

Япончууд энэ дайнд оролцож байсан талаарх ямар ч тодорхой мэдээлэл алга байгаа боловч Японы цэргийн 1200 мэргэжилтэн 46 мина илрүүлэгчид 1950 оны 10 дугаар сарын 2-ноос 12 дугаар сарын 10-нд Хойд Солонгосын баруун эрэг рүү НҮБ-ын цэргийн хүчин усан доогуур болон газраар дайрах арга байгаа эсэхийг тодруулахаар илгээгдэж байсан байна. Солонгосын дайны үед Японы оролцоо нь цэргийн хувьд ч, дипломат харилцааны хувьд ч чухал асуудал байгаагүй боловч Сталин Өмнөд Солонгосын эсрэг Хойд Солонгосын дайралтыг ашиглан аз туршиж байсан шалтгааны нэг бөгөөд Японы цэргийн хүч дахин сэргэж Өмнөд Солонгосыг Зөвлөлт рүү цохилт хийх эргийн хяналт болгон ашиглах боломжыг тасалдуулсан ажээ.

АНУ-тай шууд цэргийн мөргөлдөөнд орохоос зайлсхийхээс үл хамааран Сталин эцэстээ Хятадын хуурай замын цэргийг Солонгост нэвтрэх замд нь агаараас хамгаалахаар зөвшөөрсөн байна. Америк агаараас ширүүн бөмбөгдөж байсан учир ХАЧА арай хийж Солонгосын дайнд оролцож эхэлсэн бөгөөд тэдэнд өөрсдөд нь агаараас хамгаалалт байгаагүй байжээ.

1950 оны 11 дүгээр сарын 1-нд Зөвлөлтийн агаарын хүчин анх удаагаа Америкийн онгоцтой Солонгос руу нэвтрэх “Хятадын ардын сайн дурынхны” зам болох Ялу мөрний гүүрэн дээр тулалджээ.

Баримт-35, Мао Зедунд илгээсэн Сталины цэргийн элч С.И.Захаров Зөвлөлт, Америкийн онгоцуудын тулалдааны эхний өдрийн үр дүнг 1950 оны 11 дүгээр сарын 2-нд илгээжээ. Захаров илтгэлдээ: 1950 оны 11 дүгээр сард Манжуурын баазуудаас Солонгосын нисэгчид агаарт ниссээр байгаа ба Америкийн онгоцууд Манжуурын агаарын бааз болон Хойд Солонгосын байнуудыг хүчтэй бөмбөгдсөөр байгааг илтгэсэн байна. Солонгост байсан Зөвлөлтийн агаарын хүчнийхэн Америкийн бөмбөгдөгч онгоц болон байлдааны онгоцууд нь өөрсдийг нь гүйцэхгүй болохыг “баталж” дэврүүн мэдээлж байжээ.

Баримт 38, Өмнөх 12 өдрийн дотор Америкийн 23 онгоцыг сөнөөж Ялу мөрнийг гатлахад Зөвлөлтийн онгоцууд баатарлаг гавьяа байгуулсан гэж Сталинд талархлаа илэрхийлжээ. Мөн Мао-гийн мэдээнд ч Сталин талархаж, Хятад руу нэмэлт шинэ загварын МиГ-

15-ыг илгээж, агаарын корпуст командын аппарат зохион байгуулснаар Хятадын агаараас дэмжих хүчинг хүчирхэгжүүлсэн болох нь харагдаж байгаа юм. Дараах хэдэн саруудад Солонгос дахь Зөвлөлтийн агаарын хүчний оролцоо асар их нэмэгдсэн байна. Гэхдээ Сталин Солонгост Зөвлөлтийн онгоцууд үзэгдэх болсноос хойш Зөвлөлтийн ашиг сонирхлын хохиролыг багасгахын тулд Зөвлөлтийн агаарын хүчийг орлож чадахуйц Хятадын нисгэгчдийг аль болох түргэн сургахыг Зөвлөлтийн Агаарын хүчинд тушаажээ.

Солонгос-Манжуурын хил дагуух зурвасыг Америкийн онгоцуудаас хамгаалахаас гадна ЗХУ Хятад, Хойд Солонгост цэргийн хангамж, зөвлөхүүд илгээн тэдний дайны ололтод гол үүрэг гүйцэтгэжээ. Хятад, Хойд Солонгосын хүсэж байсан гол зүйлс нь зэвсгийн хангамж, зөвлөхүүд байсан ба Сталин 1953 оны 3 дугаар сард нас бартлаа Мао Зедун болон Ким Ил-сонъ нартай харилцан солилцож байсан мэдээллүүдийн дийлэнх нь энэ тухай юм. Хамгийн сонирхолтой нь олон янзын зэвсгийн хангамжуудын тоо, хэзээ илгээх болон төлбөрийн асуудлаар Мао, Ким нартай Сталин өөрийн биеэр хэлэлцээр хийдэг байжээ. Сталин хангамжийн талаар ингэж санаа тавьж байсан нь Дэлхийн II дайны дараах сэргээн босголт зөвлөлтийн үйлдвэрүүдэд ногдож байсан болохоор тэднийг дэмжих гэсэнтэй мөн холбоотой байв. Саяхан ил болсон Хятадын эх сурвалжид Мао Зедун болон Пэн Дэхуай нарын Солонгосын дайны үед гүйцэтгэсэн баримтууд ч үүнийг батлаж байна. Тэд Сталинд цэргийн нөхцөл байдлыг мэдэгдэж, ажиллагаануудын явуулж болзошгүй дайралт, “4 дэх ажиллагаа”-г төлөвлөх, 1951 оны 6 дугаар сарын эхэн үед ерөнхий стратегийг төлөвлөх зэрэг “олон улсын байдалтай холбоотой” асуудлаар байнга зөвлөгөө авч байжээ. Сталин хүссэн үедээ цэргийн зөвлөгөө өгдөг байжээ. Жишээ нь 1950 оны 6 дугаар сарын 5-нд зөвлөж байсан байдлаас үзэхэд тэрээр Хойд Солонгосын хэрэгт илүү их оролцдог байсан ба заримдаа шууд командалж байжээ. Хятадууд дайны талбарт тэргүүлэх хариуцлагатай байсан бол Зөвлөлтүүд дайны үед коммунистуудын ар талд дипломат болон стратеги боловсруулахад гол үүргийг гүйцэтгэж байв.

1950 оны 11, 12 дугаар сард Зөвлөлтийн ГЯЯ-ны сайд А.Вышинский Жоу Энлайд БНХАУ НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлд орох асуудал тавих хамгийн сайн аргыг зөвлөсөн боловч хариуд нь Америкчууд болон НҮБ-аас “Солонгост дайн өдөөгч, түрэмгийлэгч улс” гэсэн тогтоолын үг сонссон юм.

1950 оны 12 дугаар сард Нью-Йоркт, НҮБ-ын төлөөлөгчид БНХАУ-ын төлөөлөгчдөөс ямар нөхцөлтэйгээр Солонгост гал зогсоох асуудлыг зөвшөөрхөө мэдэгдэхийг шаардахад Жоу Энлай хариугаа өгөхөөс өмнө Сталинд өөрийн хэлэх гэж буй санаагаа танилцуулан Зөвлөлт Засгийн газрын санаа бодлыг нь асууж байжээ. Сталины Жоу Энлай болон ТХ-

ны удирдлага, НҮБ-д суугаа ЗХУ-ын Байнгын төлөөлөгч хоёрт нэг өдөр илгээсэн хариу нь Хятадын ардын сайн дурынханы амжилт 1950 оны 11 дугаар сард Америкт эерэгээр эргэж уг дайны талаар Сталины арга барилыг эрс өөрчилсөн байна. 12 дугаар сарын 7-нд ЗХУКН-ын ТХ-ны УТТ-ноос Вышинскийд Америкийн цэргүүд давшиж буй, Америкууд цаг хожиж, цэргүүдээ бүрэн хамгаалалалтад оруулаагүй байгаа энэ үед Солонгост цэргийн ажиллагаа зогсоох тухай тогтоол оруулж байгаа нь АНУ-ын өргөн барьсан Солонгост гал зогсоох тогтоол нь буруу зүйл гэж мэдэгджээ. Үүнтэй зэрэгцэн Сталин Жоу Энъяйд “Сөүл хот чөлөөгдөөгүй байхад Хятадууд бүх хөзрөө дэлгэх цаг биш, АНУ, НҮБ хоёр өөрийн чинь тавьсан энхийн гэрээнд санал өгөхүйц тийм овжин стратеги боловсруул” гэжээ.

Баримт 52, 1951 оны 1 дүгээр сарын 11-нд НҮБ тогтоолоо өргөн барихад, Жоу Энъяй Сталины зөвлөгөөг авахаар дахин хандсан бөгөөд Сталины тооцоолж байсанчлан БНХАУ НҮБ-ын тогтоолоос татгалзжээ.

Баримт 65, 1951 оны 6 дугаар сарын 5-нд Мао Зедунд илгээсэн мэдээнд: Сталин, Хятад болон Зөвлөлтийн хил рүү өнгөлзөж байсан Америкийн аюул заналхийллийг Хятадууд дайны талбар дээр амжилттай няцаасны дараа Сталин энэ дайнд шинэ чиг хандлага барих болсон байна. Тэрээр Мао Зедунд “Солонгосын дайныг дуусгах гэж яарсаны хэрэггүй. Нэгэнт дайн эхэлсэнээс хойш нэгдүгээрт, Хятадын цэргүүдэд өнөөгийн дайны талбараас сурч судлах боломж олгох хэрэгтэй, хоёрдугаарт Америк дахь Трумэны дэглэмийг үгүйсгэж Англи-Америкийн цэргүүдийн нэр сүрийг унагах хэрэгтэй” хэмээн Мао Зедунд мэдэгдсэн байна. Сталины хэлсэн Хятадын хувьд суралцах үнэтэй сургамжид Мао хэрхэн хандсан талаар баримт байхгүй ба нэг бодлын Солонгост хэтэрхий олон шархдагсадтай байсан болохоор Хятадын удирдлагад тийм зориг тэвчээр байгаагүй болов уу. Учир нь тэдгээр шархдагсад дайны төгсгөлд олон зуун мянгаараа нас нөгцсөн юм. Гэсэн ч тухайн үед Мао Сталинтай харилцаатай байсан нь Хятадын удирдагчийн өөрийнх нь санаанд нийцэж АНУ-ын саналыг хүлээж авах хүртлээ дайныг үргэлжлүүлэхээс буцахгүй байсныг харуулж байна.

Солонгосын дайныг үргэлжлүүлэх Сталины сонирхлыг үл харгалзан, хүнд гарз хохирол амссан хятадууд болон 1951 оны 4, 5 дугаар сарын дайралтад ялагдал хүлээсэн Хойд Солонгосын цэргүүд Коммунистуудын Холбоог НҮБ-ын командлалтай хэлэлцээр эхлүүлэхэд хүргэсэн байна. 6 дугаар сарын 5-нд НҮБ-д суух Зөвлөлтийн элчин сайд Я.Малик Америкийн дипломатч, элчин сайд Жорж Ф.Кеннанд хэлэхдээ: “Зөвлөлт Засгийн газар энх тайвныг хүсэж байна, мөн Солонгосын дайны асуудлыг аль болох хурдан энхийн аргаар шийдвэрлэхийг хүсэж байна” гээд АНУ-д “Хойд Солонгос болон Хятадын Коммунистуудтай энэ талаар холбоо тогтоохыг зөвлөжээ”.

Хэдэн өдрийн дараа Ким Ил-сонь болон Зөвлөлттэй дотно харилцаатай байдаг Хятадын удирдагчдийн нэг Гао Ган нь Сталинтай нөхцөл байдлын талаар хэлэлцэхээр Москва руу морджээ. Мао Зедун НҮБ-тэй хэлэлцээр хийхийг зүйтэй гэж үзсэн учир нь дараачийн 2 сарын турш Хятад, Хойд Солонгос хоёр батлан хамгаалах байр суурьтай байх ёстой байлаа. Хэрэв Хятад, Хойд Солонгос хоёрын цэргийн хүчин энэ үед “дайсны” дайралттай тулахаас зайлсхийж чадсан бол 8 дугаар сар гэхэд тэд өөрсдийн шинэ дайралтаа хийх хангалттай хүчтэй болох байжээ.

Гао Ган (1905-1955) ХКН-ын ТХ-ны УТТ-ны гишүүн бөгөөд Зүүн хойд Хятадын Ардын Засгийн газрын тэргүүн, ХКН-ын ТХ-ны Зүүн хойд товчооны нарийн бичгийн даргын алба хашиж байсан тэрбээр БНАСАУ-д цэргийн тусламж үзүүлэхийг Хятадын удирдлагын дотроос хамгийн шаргуу эрмэлзэж байсан зүтгэлтэн юм. Солонгост туслах асуудлаар ЗХУКН-ын ТХ-ны байр суурийг дэмжиж, ЗХУ-ын жишгээр Хойд Солонгост хамгийн хүнд сорилтын үед түүнийг дэмжих үйлст БНХАУ жинтэй хувь хандив оруулах ёстой гэж тэрбээр шаргуу шаардаж байжээ. ХКН-ын ТХ-ны УТТ америкчуудийн эсрэг Солонгосын дайнд оролцох уу, оролцохгүй юу гэсэн асуудлыг гурван удаа хэлэлцжээ. Солонгост Хятадын “сайн дурын” армийг явуулах замаар БНАСАУ-ыг дэмжихээр шийдвэрлэхэд Гао Ган ХКН-ын УТТ-ны гишүүний хувьд Мао Зедунд багагүй нөлөөлжээ. Дайны үед Манжуур нь Хятадын “сайн дурынхны” армийн тулгуурлах гол бааз болж байв. Байлдаж байгаа Солонгосын цэрэг хийгээд Хятадын “сайн дурынханд” зориулсан цэргийн техник, бусад ачаа барааг Манжуурын төмөр замаар дамжуулан тээж байв. Манжуурт нэгэнт байрлаад байсан Зөвлөлтийн агаарын цэргийн хүчин, агаараас эсэргүүцэн хамгаалах анги нь Порт-Артурын тэнгисийн цэргийн баазад байрлаж байсан Зөвлөлтийн зэвсэгт хүчинтэй хамтран америкийн халдлагаас БНХАУ-ыг найдвартай халхлан хамгаалж, армия Ялу голыг гатлуулан Хойд Солонгост нэвтрэхэд нь шийдвэрлэх үүрэг гүйцэтгэжээ.

Хятад орон даяар “Канмэй, Юаньчао!” (Америкийг эсэргүүцэж Солонгост туслья!) гэсэн лоозонгийн доор өрнөсөн томоохон компаниг ажлыг Гао Ган Манжуурт санаачилжээ. Хятадын сайн дурынхан болон Солонгосын ардын армийн цэргүүдэд зориулсан мөнгө хөрөнгө, хоол хүнс, хувцас хунар цуглуулах ажил эхлээд Манжуурт дараа нь Хятад даяар өрнөжээ.

ХКН-ын ТХ-ны УТТ Солонгост илгээсэн сайн дурынхны армийн байлааны ажиллагаатай холбогдуулан Бээжингээс зааж төлөвлөсөн бүх арга хэмжээ хэрхэн хэрэгжиж байгаа хийгээд Манжуурт зохиож буй батлан хамгаалах арга хэмжээг Манжуурын түшиц газраас шууд биечлэн удирдаж байх ажлыг ХКН-ын ТХ, БНХАУ-ын Засгийн газрын өмнө хариуцах үүргийг Гао Ганд ногдуулжээ.

Баримт 69. Энэ үед энхийн гэрээ хэрэгтэй гэдэг дээр Сталин Мао Зедунтай санаа нийлсэн бөгөөд НҮБ-д суугаа Москвагийн элчин сайдыг тохирох санаачлага гаргахыг үүрэг болгожээ. Трумэний Засаг захиргаан дахь цэргийн хүч хэрэглэх дуртай улс төрчид, цэргийнхэн Солонгостой хэлэлцээр хийхийн эсрэг байсан, дайсан хүчээ сэлбэхээр зөвхөн хугацаа хожихыг хүсэж байна гэж үзсэн ба тэр нь чухамдаа үнэн байсан юм. 1951 онд НҮБ-ийн хүчнийхэн Хятадын нөхцөл болон Хойд Солонгосын цэргүүдэд хийсэн Мао Зедуны шалгалтаар 1951 оны 6, 7 дугаар сард Хятадууд хамгаалалтаа бэлдэхээс өмнө ашигтай байрлалаа олж байсан бөгөөд Хоёр Солонгосын хилийн зурвас дээр ч сайн байрлал, бэлтгэлээ хангаж байжээ.

1951 онд дайны талбар дахь өөрийн байр сууриа бэхжүүлэхээр эхлээд цаг хожихын тулд Мао Зедун хэлэлцээр явуулж эхэлсний зэрэгцээ 1951 оны 7, 8 дугаар сард Сталинтай нягт харилцаа холбоотой байсан ба хэрвээ тэрхүү хэлэлцээрүүдийн ашигтай сайн талуудыг нь олж харсан бол энхийн гэрээг хийх магадлалтай байв. Гэсэн ч Сталин хэлэлцээрүүдийн талаар хатуу байр суурьтай байсан бөгөөд Америкчууд энхээ гэрээ хийхийг хэнээс ч илүү хүсэж байгаа болохоор Хятад, Хойд Солонгос хоёр хатуу байр сууриа хадгалж яаравчилсан шинжгүй байж, хэлэлцээрийг хурдан дуусгах гэсэн сонирхол үзүүлж болохгүй гэж зөвлөж байжээ.

Баримт 95, 1952 онд гэхэд дайн үргэлжилсээр байсан бөгөөд Хойд Солонгосчууд дайныг дуусгахыг маш их хүсэж байжээ. Харин Хятадуудын дайнд оролцох арга барил нь харьцангуй өөрчлөгдсөн байв. Нэг талаас Мао Зедун энхийн гэрээний тааламжгүй нэр зүүж, ХАЧА-ийн нэр сүрийг унагахаас зайлсхийж байсан нь тодорхой байв. 1952 оны 8 дугаар сард Жоу Энълай Москвад Сталинтай уулзахдаа “зарчмын хувьд Хятадын удирдлага шархагдсад, олзлогдсодыг эх орон руу нь буцаах асуудлаар Америктай зөвшилцөж чадахгүй” гэжээ. Цааш нь “Мао Солонгосын дайн Хятадад давуу тал авчирсан гэж үздэг, яагаад гэвэл энэ дайн АНУ-ыг дэлхийн III дайнд бэлтгэхээс холдуулсан. Нарийндаа хэлбэл, Хятад улс Солонгост Америкчуудтай байлдаж байхдаа тэр дайныг 15-20 жилээр хойшлуулахад туслалаа” гэжээ. Гэхдээ нөгөөтэйгүүр, Жоу ярианыхаа төгсгөлд хэрэв америкчууд шархдагсад, олзлогдсодын асуудлаар зарим нэг буулт хийвэл Коммунистууд хүлээж авах нь зүйтэй гэж мэдэгдсэн байна.

Энхийн хэлэлцээрүүдийн олон саруудад Хятадын удирдлага Солонгосын дайны талаар юу бодож санаж байсныг улам тодорхой болгохын тулд Хятадын баримтуудыг үзэх хэрэгтэй. Гэсэн ч 1966 онд Зөвлөлтийн ГЯЯ-наас гаргасан Солонгосын дайны талаарх дотоод нууц тайлан мэдээлэлд Сталины нас барсан 1953 оны 3 дугаар сард Бээжин дайныг дуусгах их хүсэлтэй байсан гэжээ. Энэ мэдээлэлд өгүүлснээр

Жоу Эньлай Сталины шарилыг сүүлчийн замд нь үдэх үеэр энхийн гэрээг яаравчлан хийхэд ЗХУ-ыг туслахыг санал болгон хүсэж байжээ.

Баримт 12, 1953 оны 3 дугаар сарын 19-нд гарсан ЗСБНХУ-ын Сайд нарын Зөвлөлийн тогтоол нь Сталины дараах удирдлагын нэн тэргүүний зорилт нь Солонгосын дайныг дуусгавар болгох явдал байсан бөгөөд Сталины дараах бухимдал, эргэлзээ дүүрэн үед шинэ удирдлага нь энэ чухал гадаад бодлогын асуудлыг ердөө 2 долоо хоногийн дотор эцэслэн шийдвэрлэсэн байна. Иймээс баримт нотолгоонууд Солонгосын дайныг үргэлжлүүлэх гол хүчин зүйл нь Сталины хүсэл байсан бөгөөд түүнийг нас барсаны дараахан Коммунистуудын Холбоо энхийн гэрээ байгуулах шийдвэртэй алхам хийсэн байна.

СНЗ-ийн тогтоол гарсан хугацааны хувьд АНУ-ын цөмийн зэвсэг хэрэглэнэ гэсэн сүрдүүлгээс илүү эцэстээ энхийн гэрээнд хүргэсэн Сталины нас баралт байжээ. Хожмоо Эйзенхауэрын Засаг захиргаа Хятад улс энхийн гэрээ хийхгүй бол цөмийн зэвсэг хэрэглэнэ гэж Бээжинд “алдаагүй зөв сануулга” өгсөний буянаар Пань Мынь-жомд байсан мухардалаас гарлаа гэж сайшаан зөвтгөжээ. 1953 оноос хойш Америкийн дээрх шаардлага нь стратегид нь чухал нөлөө үзүүлжээ. Гэхдээ Эйзенхауэрын сүрдүүлж байсан цөмийн зэвсэг нь 1953 оны 5 дугаар сард Зөвлөлт Засгийн газар дайныг дуусгавар болгоод 2 сар болсоны дараа хийгдсэн байна. Үүнээс үүдээд цөмийн зэвсгийн талаарх дипломат гэрээний талаарх маргааны маш чухал шинэ баримтуудыг Оросын баримтууд олгож байгаа юм. Сүүлчийн хоёр баримт нь Солонгосын дайны талаарх Мао Зедуны хандлагын сонирхолтой мэдээлэл ба дайны үед Москвагаар харилцах харилцаанд нь ямар нөлөө үзүүлсэнийг харуулж байна.

Баримт 114, 1953 оны 6 дугаар сарын 28-нд Бээжинд Зөвлөлтийн албаныхантай уулзаж байхдаа, Мао мэдэгдхүйц өдөөн хатгасан шинжтэй байсан хийгээд энэ дайн нь Хятадын их ялалт байсан гээд цэвэр цэргийн үзэл санааны үүднээс нь үзвэл ядаж нэг жил Америктай байлдаж дайныг үргэлжлүүлсэн бол муугүй л байх байсан гэж хэлжээ. Магадгүй Мао Сталины дараах Москвагаар харилцах харилцаагаа дахин тодоор тодорхойлохын тулд Оросуудын өмнө баярхсан байж болох юм. Тиймээс Маогийн талаар хэн нэг нь хатуу бодолтой болохоос өмнө Зөвлөлтийн баримтуудыг Хятадын шинэ эх сурвалжуудтай нэгтгэх хэрэгтэй. Гэсэн ч 1956 оны 4 дүгээр сард Зөвлөлтийн элчин сайдтай Бээжинд хийсэн ярилцлагаас харахад Солонгосын дайн БНХАУ, ЗСБНХУ-ын харилцаанд ямар их нөлөөлснийг харуулж байна. Сталин Мао Зедуныг Солонгос руу хүчтэй дайралт хийхийг шаргуу шаардаж байсан боловч БНХАУ-ын Америкийн эсрэг хийсэн “гайхалтай ялалт” болон Москва холбоотондоо гар татуу хандсан явдлууд нь Бээжингийн коммунист Засгийн газрыг Зөвлөлтийн удаа дараагийн шаардлагуудад хүлцэнгүй биш байхад сургасан байж болох талтай. Хүйтэн дайны талаар шинээр хэвлэгдсэн

эдгээр эмхтгэлийн бусад баримтуудаас үзэхэд, Ерөнхийлөгчийн Архивийн ил болгосон баримтууд нь Солонгосын дайн болон Сталины жилүүд дэх Зөвлөлтийн гадаад бодлогуудын талаарх мэдлэгийг өргөжүүлж, тэгэх тусмаа Хятадын шинэ Засгийн газартай харилцах Зөвлөлтийн харилцааны тухай мэдлэгийг тэлж өгч байгаа юм.

Харин коммунист Хятад Солонгосын дайнд орсон үеэс хойш Чан Кайшигийн Хятад АНУ-ын тэргүүлсэн НҮБ-ын цэргийн ажиллагааг бүх талаар эл тод дэмжиж, НҮБ-ын Аюулгүй Зөвлөлд байнгын маргаан үүсгэж байснаар зогсохгүй ЗХУ-ын “хүчээр булаан авсан Хятадын алдагдсан газар нутаг” болох Гадаад Монгол Хойд Солонгост цэрэг илгээсэн мэтээр илэрхий мушгин гуйвуулж байсан юм.

Солонгосын дайнаас шалтгаалан Азид хүйтэн дайныг эхлүүлэхэд Ким Ил- Сонь, И.В.Сталин, Мао Зедун нарын зэрэг тухайн үеийн удирдагчид энэ дайнд чухам ямар үүрэг гүйцэтгэсэн үнэн түүх нь анхаарал татсан бөгөөд судлаач миний бие 1996 оны намар БНСУ-ын ГЯЯ-ны Үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын институтэд Солонгосын дайны уг сурвалжийн талаар зарим шинэ баримт материал, эх сурвалжийг хайсан юм. 1994 оны 7 дугаар сарын 20-нд Өмнөд Солонгосын Засгийн газар хуучин ЗХУ-ын ГЯЯ-нд байсан Солонгосын дайнд холбогдох баримт бичгүүдийн зарим багцыг Солонгосын ГЯЯ-нд дахин шинээр хүлээлгэн өгсөн талаар албан ёсоор мэдэгджээ. 1950 оны 6 дугаар сарын 25-нд эхэлсэн Солонгосын дайны уг сурвалжид холбогдох зарим материалууд үнд хамрагдсан юм.

Ким Ил-соны гүйцэтгэсэн үүрэг

1949 оны 1 дүгээр сараас эхлэн Ким Ил-сонь Өмнөд Солонгос руу бүхий л хүчээрээ довтлох янз бүрийн төлөвлөгөө гаргаж байсан ажээ. Ингэж үзэх хэд хэдэн үндэслэл буйг баримтаас харж болохоор байна. Үүнд: Ким Ил-сонь ЗХУ-аас Умард Солонгост суух элчин сайд Т.Ф.Штыковт Сталинтай уулзалт товлох талаар хэд хэдэн удаа санал тавьж, Өмнөд рүү довтлох ерөнхий төлөвлөгөөнийхээ талаар Сталинтай зөвлөлдөх хүсэлтэйгээ илэрхийлж байжээ. Хэдийгээр Штыков Кимийн төлөвлөгөөний талаар хянамгай байр суурь баримталж байсан боловч эцсийн бүлэгт түүнийг Сталинтай уулзуулсан байна. 1949 оны 1 дүгээр сарын 17-нд Т.Штыков Ким Ил-соньд албан ёсоор “ЗХУ Хойд Солонгосын албан ёсны төлөөлөгчдийг 1949 оны 2 дугаар сард багтаан хүлээн авахад бэлэн байна” гэж мэдэгджээ.

1949 оны 2 дугаар сарын 5-нд Ким Ил-сонь, ГЯЯ-ны сайд Пак Хан-ёны хамт ЗХУ-тай Хойд Солонгосын хэлэлцэх асуудлын жагсаалтыг бэлтгэсэн баримт бичгүүдийн хамт ЗХУ-д иржээ. Үүнд: Умард Солонгос нь ЗСБНХУ-аас 300 сая ам.долларыг үйлдвэрлэлийн хэрэгсэл, зэвсэг, зэвсгийн нөөц болон цэргийн хэрэгсэлд зориулан зээл авах хүсэлт тавьсан байна.

Ким Ил-сонь 1949 оны 3 дугаар сарын 5-нд Москвад Сталинтай уулзахдаа Өмнөд рүү довтлох төлөвлөгөөгөө танилцуулжээ. Тэрээр цэргийн хүч хэрэглэн Өмнөд Солонгост зэвсэглэн халдах замаар Солонгосын нэгдлийг хангах талаар ЗХУ-ын удирдлагын байр суурийг мэдэх зорилт тавьсан байна. Ким, Сталин хоёрын анхны уулзалтаар тэд зарим чухал хэлэлцээрүүдийг ч баталсан юм.

1949 оны 4 дүгээр сарын 28-нд Ким Ил-сонь Штыковт хандан Сталинд хувийн захидал явуулах хүсэлт тавьжээ. Уг захидалд Умард Солонгосын зэвсэгт хүчний техник, хүчин чадлыг бэхжүүлэх талаар онцгойлон тэмдэглэсэн байх ба 1949 оны 5 дугаар сард тус төлөвлөгөөгөө улам боловсронгуй болгож, Умард Солонгосын армийг техникээр хангах, механикжуулах, 1949 оны 9 дүгээр сард агаарын цэргийн техник шилжүүлэх талаар дурджээ. Уг захидлыг Штыков 1949 оны 5 дугаар сарын 3-нд Москва руу илгээжээ. 1949 оны 6 дугаар сарын 4-нд ЗСБНХУ-ын Засгийн газар Ким Ил-сонын хүсэлтийг хүлээн авсан тухай Штыков Кимд албан ёсоор мэдэгдсэн байна.

1949 оны 8 дугаар сарын 12-ны Штыковын илтгэлд дурдснаар тэрбээр Кимд хандан: “Өөр ямарваа хувилбар байхгүй боловч БНАСАУ-ын талын тайван замаар Солонгосыг нэгтгэх саналыг Өмнөд Солонгос хүлээн авахаас татгалзвал довтолгоонд бэлтгэе”. “Ким БНАСАУ-д Өмнөд рүү довтлох ажиллагааг дэмжихэд шаардлагатай зэвсэг, техникийг ЗСБНХУ-ын тусламжаар олгохын чухлыг цохон тэмдэглэлээ” гэжээ.

1950 оны 1 дүгээр сарын 17-нд Ким Зөвлөлтийн ЭСЯ-ны Игнатев, Штыков, Фолюшенко нартай уулзаж, Өмнөд Солонгосыг хэрхэн чөлөөлөх талаар ярилцсан байна. Мөн Ким Ил-сонь Москвад Ким-Сталины 2 дахь уулзалтыг товлох санал гаргажээ. Штыков Кимийн асуулгыг Москвад дамжуулж өгчээ. 1950 оны 1 дүгээр сарын 30-нд Сталины гарын үсэг бүхий цахилгаан утас Пёнъянд ирж, Ким-тэй 1950 оны 4 дүгээр сард дахин уулзахаар болсноо мэдэгджээ.

Сталины гүйцэтгэсэн үүрэг

Сталин Хойд Солонгосын төлөвлөгөөг ерөнхийдөө зайнаас тойруу замаар хаширлан хүлээн авсан ажээ. Солонгосын дайны уг сурвалжид холбогдох Оросын Гадаад Яамны баримт бичгүүдээс иш татбал,

Сталин Бээжин, Пёнъянд сууж байсан Зөвлөлтийн ЭСЯ ба Умард Солонгос, Хятадын удирдагчидтай Солонгосын талаар (дайны талаар) харилцахдаа өөрийн жинхэнэ нэрээ маш нууцалж, Филипов гэсэн зохиомол нэр хэрэглэдэг байжээ. Эцсээ хүртэл энэ талаарх асуудалд өөрийгөө нууцалдаг байсан байна.

1950 оны 3 дугаар сарын 5-нд болсон Ким, Сталины уулзалтын баримтад бичихдээ: “Сталин хариу хэлэхдээ Умард Солонгосын цэргийн хүчин Өмнөдийн цэргийн хүчнээс үнэмлэхүй давуу биш байгаа үед ямар ч довтолгоо хийх хэрэггүй” гэжээ. Тэрбээр Өмнөд Солонгост АНУ-ын

цэрэг байрлаж байгаа бөгөөд АНУ, ЗСБНХУ хоорондоо 38 дугаар өргөрөгөөр гэрээ байгуулсан тул Сталин Өмнөдөөс Умард Солонгос руу довтолсон нөхцөлд л хариу цохилт хийе гэсэн санаа анхлан гаргаж байжээ. 1949 оны 3 дугаар сард Ким Сталин хоёрын анхны уулзалт дээр Сталин орчуулагчаараа дамжуулан “Нөхөр Ким ажил хэргийн явц ямар байна?” гэхэд Ким “бүх зүйл жин тан, бид гэнэтийн довтолгоо хийхэд Өмнөдийн ард иргэд Умардыг дэмжин бослого гарч хувьсгал эхэлнэ” гэж хариулж байжээ. Ким зөвхөн Өмнөдийнхэн л асуудал үүсгэж байна. Тэд хил зөрчиж, жижиг мөргөлдөөн байнга гаргаж байна гэж гомдолложээ. Сталин дүнсгэр царайлж “Та юу хэлнэ вэ? Зэвсэг цэргээ яасан юм бэ? Бид та бүхэнд зэр зэвсэг илгээнэ” гэжээ. “Та нар Өмнөдийнхэний шүдэнд нь цохилт өгөх ёстой”. Хэсэг бодлогоширсоны эцэст “Тэдэнд цохилт өг. Цохилт өгөх ёстой” хэмээн давтан хэлжээ.

ЗХУКН-ын Төв Хороо И.В.Сталины саналыг дэмжин 6 сарын дараа, өөрөөр хэлбэл 1950 оны 1 дүгээр сарын 17-ны Оросын Гадаад яамны баримтад өгүүлснээр Ким Штыковт “Хэрэв Он-жинд зөвхөн 3 хоног л үйл ажиллагаа явуулахыг Сталин зөвшөөрвөл бид Сөүлд 3 хоногийн дотор хүрч чадна. Он-жин хойгт дайралт хийхэд Сталинаас зөвшөөрөл хүлээж байна” гэжээ. Үүнийг Сталинд дамжуулахад 1950 оны 1 дүгээр сарын 30-нд Сталины гарын үсэгтэй цахилгаан Пёнъянд ирсэн байна. Үүнд: “Би Кимийн бухимдаад байгааг ойлгож байна. Гэвч БНАСАУ-ын удирдагч та бүхэн Өмнөдийн асуудлыг нарийн нямбай шинжиж судлахад бэлтгэх хэрэгтэй юм. Болгоомжгүй, хуумгай хандаж болохгүйг сануулж байна” гэжээ.

Мао Зедуны гуйцэтгэсэн уурэг

Солонгосын дайныг төлөвлөн бэлтгэх явцад Хятадын оролцоо ямар байсан бэ? гэдгийг авч үзэхэд 1949 оны 5 дугаар сарын 14-нд Москвад хийсэн Штыковын илтгэлд Ким Ил-сонь, Солонгосын Хөдөлмөрийн Намын ТХ ба Солонгосын Ардын Армийн улс төрийн удирдагч Ким Ий (Ким Чен Ир)-гийн Хятадад хийсэн нууц айлчлал, уулзалтын талаар тайлбарлажээ. Тэрээр эхлээд Гао Гантай, дараа нь Жоу Эньлай, Жу Дэй нартай 4 удаа уулзсан байна. Ким Ий нь Ким Ил-соны хожим нь Хойд Солонгосын дэд ерөнхийлэгч, улсын хоёр дахь дарга болгохоор итгэмжлэгдсэн хүн нь байсан бөгөөд Мао-тай нэг удаа уулзсан ажээ. Тэрээр Хятадын удирдагчидтай Манжуур дахь Ардын чөлөөлөх армийн 3 дугаар дивизийг шилжүүлэх талаар ярилцсан байна. Мао Солонгос-Манжуурын хилийн ойролцоох 2 дивизийг Умард Солонгос руу шилжүүлэхийг зөвшөөрсөн ажээ. Өмнөд Хятадад Гоминданы хүчинтэй тулалдаж байгаа 3 дугаар дивизийг сарын дараа илгээх болсон байна. Ойрын ирээдүйд Өмнөд Солонгосын эсрэг довтолох шаардлагагүй гэж Мао үзжээ. Учир нь Мао, Ким Ий-д ерөнхийдээ олон улсын байдал таатай биш байна. Ялангуяа

Гоминданы хүчний эсрэг иргэний дайнд оролцож байгаа тул ойрын үед ХАЧА-ийн цэргийг Умард Солонгост тусламжаар явуулах нь хүндрэлтэй байна гэдгээ ойлгуулжээ. Мао Ким Ий-д хандаж Умард Солонгос шийдвэрлэх үйл ажиллагаагаа Гоминданы хүчнийг Хятадын арми ялж Бүх Хятадад нэгдсэн засаглал тогтоох хүртэл хойшлуулахыг хүсчээ. 1950 оны 4 дүгээр сарын 25-нд Москвагаас буцаж ирээд Ким Ил-сонь Бээжинд суугаа БНАСАУ-ын Элчин сайд Ий Чу-юу-гаас Мао-тай хийсэн Ким Ий-гийн уулзалтын талаар мэдээлэл авчээ. Ким Ил-соны мэдэгдсэний дагуу Штыков Москвад дараах мэдээг дамжуулсан бөгөөд үнд: Мао “Солонгосын хойгийн нэгдлийн асуудал нь цэргийн хүчээр шийдэгдэх бөгөөд АНУ-ын цэргийн ажиллагаа ер шаардлагагүй бөгөөд АНУ нь БНАСАУ шиг жижиг орны тухайд дэлхийн III дайн эхлүүлэхгүй болов уу” гэжээ.

1950 оны 5 дугаар сарын 13-нд Ким Ил-сонь Мао-тай уулзахаар Бээжинд ирсэн байна. Чухал хэлэлцэх асуудал нь: нэгд, Солонгосын нэгдлийн төлөө цэргийн хүч хэрэглэх, Мао Зедун Сталины зааврын дагуу Умардад цэрэг илгээх, Сталинтай Москвад хийсэн хэлэлцээрийн үр дүнг тайлбарлах; хоёрт, хоёр улсын худалдааны гэрээнд гарын үсэг зурах; гуравт, Мао-д Москвад ярилцсан бусад асуудлын үр дүнг тайлбарлах, ХКН ба Солонгосын Хөдөлмөрийн Намын харилцаа холбоог бэхжүүлэх явдал байв.

Ким Ил-сонь Москвагийн уулзалт дээр Сталин хэлэхдээ “тухайн үеийн олон улсын байдал өмнөхөөсөө ихээхэн ялгаатай болсоор байгаа” боловч эцсийн шийдвэрийг Мао-тай хэлэлцсэний дараа гаргана гэж мэдэгдсэн бөгөөд Ким Ил-сонь Умард Солонгосын армийг 7 дугаар сарын сүүл хавьцаа Өмнөд рүү илгээх тодорхой төлөвлөгөө бэлтгэсэн тухайгаа хэлсэн байна. Энэ талаар Мао Зөвлөлт Засгийн газраас Сталины хувийн тайлбарыг 5 дугаар сарын 15-нд хүссэн байна. Төдөлгүй Мао Москвагаас хариу авчээ. Мао “Хэрвээ АНУ цэргийн ажиллагаа явуулбал Хятадын чөлөөлөх армийг Умард Солонгос руу туслахаар илгээнэ гээд ЗХУ нь АНУ-тай Солонгосын хойгийн 38 дугаар өргөрөгийн дагуу хүрээ тогтоох хэлэлцээр байгуулсан нь Зөвлөлтийг энэ тулалдаанд шууд оролцоход нь саад болох боловч Хятад улс ЗХУ-тай адил үүрэг хүлээгээгүй нөхцөлд Умард Солонгост тусалж болох юм” гэжээ.

Умард Солонгосын Ким Ил-соны эхлүүлсэн 1950-1953 оны Солонгосын дайн нь түүний Солонгос үндэстнийг Коммунизмын далбаан дор бүрмөсөн нэгтгэхийн тулд Өмнөд Солонгосыг “чөлөөлөх” үзэл санаанаас үүдэлтэй нь өнөөдөр тодорхой билээ. Тэрбээр өөрийн амжилтанд бат итгэлтэй байсан ажээ. Дайныг өдөөгч, санаачлагчийн хувьд Ким тууштайгаар Сталинг, дараа нь Маог бүрнээ ятгаж чадсан байна. Сталины үүрэг ч мөн чухал байсан нь тодорхой байна. 1950 оны 3 дугаар сараас хойш Сталин Кимийн дайны төлөвлөгөөг, хэрэв

Ким дайнд түргэн ялчихвал АНУ Солонгост цэргийн ажиллагаа хийхгүй гэсэн утгаар анхнаасаа дэмжин тусалж байжээ. Үүгээрээ Сталин Кимийн төлөвлөгөөг бүхэлд нь гэхдээ болгоомжтойгоор дэмжигч байсан гэж үзэж болохоор байгаа юм. Умард Солонгосын дэглэмд АНУ саад учруулах вий гэсэн үүднээс, гол нь БНХАУ-ын аюулгүй байдал, Сталины шахалт шаардлага зэргээс яаравчлан Умард Солонгост тусламж үзүүлжээ.

Солонгосын дайнд оролцсон Хятадын бодлого

1950 он буюу БНХАУ байгуулагдсанаас хойш нэг жилийн дараа Мао Зедун болон Бээжингийн удирдлага сайн дурынхан хэмээн нэрлэсэн цэргийн хүчнийг Хятад, Солонгосын хил дээр тулж ирээд байсан Америк тэргүүтэй НҮБ-ын цэргийн хүчний эсрэг хөдөлгөхөөр Солонгос руу илгээсэн билээ. Хэдийгээр Хятадын хөндлөнгийн түрэмгийлэл нь Ким Ил-сонын Умард Солонгосын коммунист дэглэмийг эрж буй сүйрэл мөхлөөс аварсан ч НҮБ-ын цэргийн хүчнийхнийг дарах гэсэн Бээжингийн удирдлагын итгэл найдварыг гүйцэлдүүлж чадаагүй юм. Тиймээс 1953 оны 7 дугаар сард Солонгосын дайн төгсөхөд Солонгосын улс төрийн газрын зураг чухамдаа хэвээр үлдсэн юм. Харин Солонгос дахь Америкийн цэргийн хүчний ажиллагаа, Коммунист Хятадын Чан Кайшиг дэмжиж, АНУ-ын талаар явуулж байсан сэргөлдөөн нь Хятад, Америкийн зөвшилцөлд хүрэх итгэл найдварыг эцэст нь нурааж, БНХАУ, АНУ-ын хооронд 20 орчим жил үргэлжилсэн сэргөлдөөнөөр тодорхойлогдсон Ази дахь хүйтэн дайн шинэ шатандаа дахин гарсан юм.

Шинээр байгуулагдсан Хятадын коммунист дэглэм нь эхний жилүүдэд улс төрийн нэгдэл нягтралд хүрэх, дайнд нэрвэгдсэн эдийн засгаа сэргээн босгох, мөн улс, үндэснийхээ дахин нэгдэх үйл явцыг дуусгах зэрэг томоохон сорилттой тулгарч байв. Чухам яагаад Мао бараг Өрнөдийн бүх аж үйлдвэржсэн хүчнүүдээс бүрдсэн эвсэлтэй тэмцэлдэхэд нь Умард Солонгосыг дэмжихээр шийдсэн юм бол? Энэ шийдвэр хэрхэн гарав? Солонгосын дайнд оролцох Бээжингийн шийдвэрт нөлөөлсөн яаралтай чухал хүчин зүйлс юу байв? АНУ, БНХАУ-ын хооронд гарсан шууд сэргөлдөөнд саад болох ямар нэг боломж байсан уу? Солонгосын дайнаас хойш бүхэл бүтэн 50 жил өнгөрөөд байхад эдгээр асуултын хариулт зохих хэмжээнд тодорхой болж байна.

1950-иад оны үед хүйтэн дайнд хэт өртсөн эрдэмтэн судлаачид Солонгосын дайн дахь Хятадын оролцоог олон улсын коммунист хөдөлгөөн Москвагийн хяналтан дор байна, харин Бээжин ч, Пёнъян ч тэр өөрсдийн гадаад бодлогынхоо шийдвэрийг бие даан гаргах эрх чөлөөтэй байна гэж үзэж, дэлхий нийтээр өрнөөд байсан коммунист үйл явцын дүр зураг болж харагдахыг чармайж байв. Тиймээс Солонгосын зөрчилдөөн нь нэг талд коммунистууд, нөгөө талд чөлөөт ертөнц хоёрын хоорондох түрэмгийллийн гол талбар болсон юм.

Умард Солонгосын Өмнөд рүү хийсэн түрэмгийллийг ерөнхийлөгч Харри Трумэн болон Солонгосын дайны талаарх судлаачид коммунист үйл явц дахь “сүйрлээс гараад” “зэвсэгт мөнгөлдөөн, дайн” руу орсон анхны алхам байлаа гэж үзэж байв. Солонгосын дайн дахь Хятадын оролцоо нь Москвагийн хүйтэн дайны ерөнхий байлдааны бодлогоос шууд хамаарсан ажиллагаа байв.

1960 онд Аллен С.Уайтинг үе үеийн эрдэмтдийн бодол санаанд хүчтэй нөлөөлсөн “Ялу мөрөнг дамнасан Хятад” нэртэй судалгааны бүтээлээ хэвлүүлжээ. Уайтинг барууны оюуны бүтээл, сонин сэтгүүлд нийтлэгдсэн мэдээллийг ашиглан ЗХУ-тай адилгүй коммунист Хятад нь Умард Солонгосын Өмнөд Солонгос руу хийх довтолгооны төлөвлөгөөнд шууд оролцоогүй гэж маргаж байсан ажээ. Бээжин улс төрийн аргаар сэргөлдөөнийг хязгаарлахыг хичээж байсан ба 1950 оны 8 дугаар сарын сүүлээр энэ нь бүтэлгүйтсэнд 9 дүгээр сарын эхээр цэрэг, зэр зэвсгийн бэлтгэл ажилдаа орсон байна. Уайтинг 9 сарын сарын дундуур Өрнөдийн цэргийн хүчин Инчоньд газардсаны дараа Бээжин 38 дугаар өргөрөгөөс хойш нэвтрэн орж ирж байсан НҮБ-ын зэвсэгт хүчнээс сэргийлэхийн тулд цэргийн хүчийг ашиглахыг хичээж байсан гэдгийг онцлон тэмдэглэжээ. Бээжин тулгараад байсан аюулын дохио санамжийг Вашингтон болон генерал Дуглас МакАртур “үл тоосны дараахан нь” дайнд оржээ. Тэгээд Бээжингийн удирдлага Хятад, Солонгосын хилийн аюулгүй байдал нь туйлын ноцтой гэж үзэж байжээ. Уайтинг Солонгосын хямралын талаар баримталж байсан бодлого нь Америкийн Хятадын үндэсний аюулгүй байдалд заналхийлж байсан гэх зэрэг Хятадын коммунист байр суурин дээр тулгуурлаж байсан гэж өгүүлсэн байна. Хятадын архивын материалын хомс байдлаас болоод Уайтинг дайнд оролцох шийдвэрийг гаргасан үйл явцын талаар дүн шинжилгээ хийхээс илүү Бээжингийн удирдлагын шийдвэр гаргасан тухайн үеийн байр байдлын талаарх дүн шинжилгээг илүү их хийсэн байна.

1960-аад оны сүүлч, 1970-аад оны үед Вьетнам дахь Америкийн дайралт, Хятад-Америкийн харилцааны тогтвортой байдал, архивын шинэ баримт бичиг зэргээс үүдэн Солонгос дахь Хятад, Америкийн сэргөлдөөнийг шүүмжлэх хандлага гарч ирсэн байна. Уайтингийн судалгааны ажил дээр тулгуурлан Солонгосын дайнд оролцох шийдвэр гаргахад нөлөөлсөн гол хүчин зүйл болсон Хятадын үндэсний аюулгүй байдалд ХКН-ын удирдагчид ихээхэн анхаарч буйд эрдэмтэн судлаачид илүү анхаарлаа хандуулж байжээ. Тэд ерөнхийдөө Хятад эдийн засгаа дахин сэргээх, улс төрийн нэгдэл нягтралд хүрэх, Тайванийг чөлөөлөх зэрэг асуудал дээр ихээхэн бэрхшээлтэй тулгарсан учир Бээжин Солонгосын дайнд тийм ч таатай байгаагүй хэмээн маргалдаж байжээ. Тэдгээр эрдэмтдийн ихэнх нь Солонгосын дайнд оролцох Бээжингийн шийдвэр нь Хятадын газар нутгийн аюулгүй байдалд тулгараад байсан

аюулд дуртай дургүй хийсэн хариу үйлдэл байсан гэж онцлон тэмдэглэжээ. Мөн тэдний ихэнх нь Хятадыг түрэмгийлэл хийхэд аргагүй хүргэсэн гэж үзэж байхад нөгөө хэсэг нь НҮБ-ын цэргийн хүчнийхэн хилийн 38 дугаар зурвас дээр үйл ажиллагаагаа зогсоосон бол Хятад түрэмгийлэл үйлдэхгүй байсан гэж үзсэн байна.

Оросын шинэ эх сурвалжаас үзвэл, 1950 оны 8 дугаар сарын эхээр Инчоньд газардсанаас 1 сар гаруйн өмнө Мао Зедун болон Бээжингийн удирдлага Солонгос руу цэргээ илгээх сонирхолтой байсан ба Хятадын цэрэг, улс төрийн бэлтгэл аль сарын өмнө эхэлжээ. Мөн Солонгосын дайнд оролцох шийдвэр нь Хятад-Солонгосын хилийн аюулгүй байдлын хамгаалалтаас бүр холуур тойрсон асуудал байв.

Мао болон түүний холбоотнууд Чан Кайшийг дэмжигч Америкаар толгойлуулсан нэгдсэн үндэстний цэрэгт цохилт өгч, Солонгосын хойгт гялалзсан ялалт байгуулахыг эрмэлзэж байсан байна. Энэ нь Тайванийг чөлөөлж, гоминьданы хүчийг хиар цохиход Мао Зедун болон БНХАУ-ын хувьд нэр төрийн хэрэг байжээ.

Солонгосын дайн дахь Хятадын оролцоо нь Хятад, Солонгосын хилийн аюулгүй байдлыг хамгаалах гэж үзэхээс илүү төвөгтэй асуудал бас бий юм. Хятадын дайнд оролцох болсон шалтгааныг мэдэхийн тулд эхлээд Солонгосын хямралын үед Хятадын аюулгүй байдал, эрх ашиг нь ямар хэмжээгээр, хэрхэн яаж хэрэгжиж болох талаар тунгааж байсан ХКН-ын удирдагчдын бодол эргэцүүллийг шинжин дүгнэх хэрэгтэй. Энэ дүн шинжилгээ нь Хятадын гадаад харилцааны талаар ХКН-ын удирдлагын бодож байсан гол хүчин зүйлсийн талаар өргөн хүрээтэй дүн шинжилгээг шаардана. Эдгээрийн дундаас хамгийн голлох хүчин зүйлс нь ХКН-ын удирдагчдын гадаад ертөнцийн талаарх байр суурийн ойлголт, Хятадын коммунист хувьсгалын зорилт, мөн чанар, ХКН-ын аюулгүй байдлын стратегийн бодлого, гадаад бодлого дахь нөлөө, ХКН-ын гадаад байдал дахь дотоод бодлогын нөлөө, мөн түүх, соёлын хүчин зүйлсийн хөшүүрэг зэрэг юм.

Коммунист Хятадыг гарч ирж буй шинэ хувьсгалт хүчин талаас нь дүн шинжилгээ хийх шаардлагатай. 1949 оны үе рүү анхаарлаа хандуулбал эхлээд ХКН-ын гадаад бодлогын дотоод эх сурвалжууд, намын удирдлагын гадаад ертөнц ба үүнд эзлэх Хятадын байр суурийн талаарх ойлголт, мөн ХКН-ын бодлого боловсруулах бүтэц зохион байгуулалт дахь Маогийн гүйцэтгэх үүрэг зэргийг судалж үзэх ёстой. Хоёрт, ХКН ба АНУ хоёрын хооронд хэрхэн сөргөлдөөн гарсан, Бээжин Москва хоёрын хоорондох стратегийн хамтын ажиллагааны талаар судлах хэрэгтэй ажээ. Солонгосын дайн эхлэхийн өмнөх өдөр Бээжин, Вашингтон хоёр бие биенээ аюултай дайсан мэтээр хүлээн авч, Хятад, Америкийн сөргөлдөөний үе шат тавигджээ, Гуравт, 1950 оны 6 дугаар сарын сүүлчээс 10 дугаар сар хүртэл Солонгосын хямралын

үеийн Бээжингийн баримталж байсан бодлого энд Солонгосын дайнд оролцох шийдвэр хэрхэн гарсан болоод энэ нь дотоод ба гадаад шалгууруудтай хэрхэн тэнцэж гарсан талаар авч үзэх хэрэгтэй. Дайнд оролцох Бээжингийн шийдвэр нь Солонгосын хямралын үр дүн Хятадын дотоодын болоод олон улсын ашиг сонирхолд нөлөөлөхүйц хэмжээнд байна гэсэн итгэл үнэмшил дээр тулгуурласан байна.

1980-аад оны дунд үеэс хойш хийгдсэн Хятадын шинэчлэлт, нээлттэй бодлогын ачаар эдгээр асуудал дээр судалгаа шинжилгээ хийхэд илүү дөхөм үзүүлэх материал шинээр гарч иржээ. Эдгээр шинэ эх сурвалж нь Солонгос дахь Бээжингийн түрэмгийлэлд оролцож явсан хүмүүсийн дурдатгал, Хятадын судлаач шинжээчдийн өгүүлэл, архивын мэдээ баримтууд, ХКН-ын ТХ-ны хэвлэлийн товчооны баримт бичгүүд, Мао Зедунтай холбоотой байсан бичиг баримтуудыг нэгтгэсэн товхимол зэрэг юм. Гэвч Солонгосын дайнд БНХАУ оролцсон бүхий л учир шалтгааныг Оросын архивийн шинэ баримтууд “хангалттай” өгч байна.

Солонгосын дайн ба Тайвань, Хятадын талаарх АНУ-ын бодлогын өөрчлөлт

Хятадын эх газрын хэсэгт коммунист Маогийнханд ялагдсан Чан Кайшигийн бүлгийг үлдэгдэл хүчээ Тайвань болон Гэнхуле арлууд дээр шилжүүлэн байрлуулжээ. Хятадын үндэсний баялаг, улсын архив, алтны нөөц, эртний түүх, соёлын дурсгалт зүйлсийг ч аваачсан байна. Тайванийг чөлөөлөх, Гоминьданы эцсийн түшиц газрыг эзлэн улмаар Хятад дахь иргэний дайныг дуусгах нь ХКН-ын тунхагласнаар хятадын ард түмний үндэстний нийтийн зорилт болов.

БНХАУ тунхагласны дараах эхний саруудад АНУ-ын Засгийн газар энэхүү арал Хятадад хамаарагдана гэдэгт эргэлзэхгүй байна гэдгээ удаа дараа мэдэгдэж байсан юм. АНУ-ын Төрийн департаментаас 1949 оны 12 дугаар сарын 22-нд гадаадад суугаа Төлөөлөгчдийн газрууддаа илгээсэн нууц удирдамж нь Тайваний асуудлаар АНУ ямар байр суурьтай байсныг харуулав. Удирдамжийн гол заалт нь:

Нэгт. Тайвань бол улс төр, эдийн засаг, түүх, газар зүйн хувьд Хятадын хэсэг мөн.

Хоёрт. Олон нийтийн болон эх сурвалжуудын нотолж буйгаар гоминьданыхан Тайваньд бас ялагдана. Гоминьданы дэглэмийн үед иргэний болон цэргийн нөхцөл байдал илт муудсан нь үүний үндэслэл болж байна.

Гуравт. Тайвань бол цэрэг дайны онцгой ач холбогдолгүй газар. Номхон далай дахь Америкийн хамгаалалтад түүнийг стратегийн чухал ач холбогдолтой гэж өргөн дэлгэрсэн санаа бол буруу ташаа болно.

Дөрөвт. Тайвань арал дээрх цэргийн баазын талаар АНУ онцгой сонирхсон зүйл байхгүй. Арал дээр бааз байгуулах шинэ газар эрж хайх, тийш нь цэрэг, далайн цэргийн анги салбарыг илгээх, зэвсгээр

хангах нь АНУ-аас цаг хугацаа шаардах, аз туршсан хэрэг болохсон билээ. Сайнаар бодоход энэ нь дотроос нь гарахад нэлээд хэцүү тийм аюултай байдлын шинэ бүс нутгийг буй болгочихож ч болох, муугаар бодоход цэрэг дайны илт мөргөлдөөний эхийг тавьж мэдэх юм. “Арлыг АНУ-ын гарт байх цайз болгон хувиргах зорилгоор хуйвалдаан хийж байна гэж коммунистууд АНУ-ыг шүүмжилж байна. Цаашилбал тэд бас АНУ-д түрэмгий империализмын пайз зүүх гэж оролдож байна” гэж уг удирдамжид дурдсан байна.

Тавд. Тайваний бүрэн статус Японтой хийх энх тайвны гэрээгээр тодорхойлогдох ёстой гэсэн мэдэгдэл хийхээс зайлсхийх эдгээр байв.

Ерөнхийлөгч Х.Трумэн 1950 оны 1 дүгээр сарын 5-нд “Хятадын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг олон улсын зүгээс хүндэтгэхийг” ч уриалав. Цааш нь мэдэгдэхдээ: “АНУ Формоз юмуу, Хятадын өөр бусад нутаг дэвсгэрийг эзлэн түрэмгийлэх гэсэн ямар ч санаархал байхгүй”, “онцгой эрх, тусгай эрх ямба олж авах юмуу Формоз арал дээр цэргийн бааз байгуулахыг эрмэлзээгүй байна” АНУ “Хятад дахь иргэний мөргөлдөөнд хөндлөнгөөс оролцохгүй болно” гэжээ. Тэрбээр Тайванийг Хятадад эргүүлж өгөх тухай 1943 оны Каирын болон 1945 оны Потсдамын тунхаглалыг иш татаж, тэрхүү заалтыг Япон хүлээж авсан юм гэжээ.

Эдгээр гэрээ хэлэлцээр, баримт бичгийн дагуу Тайванийг Хятадад эгүүлэн өгсөн бөгөөд 1945-1949 онд АНУ болон бусад холбоотон гүрнүүд Хятадаас энэ арал дээр бүрэн эрхээ хэрэгжүүлэхийг зөвшилцөн тохиролцсон юм. Иймээс Хятадыг газар нутгийнхаа энэ хэсэг дээр тусгаар тогтнолоо олоход нь АНУ Солонгосын дайн эхлэх хүртэл эргэлзэж байгаагүй ажээ. Солонгост дайн эхлэхээс өмнө АНУ-ын дипломат албаныхан ч Номхон далай дахь Америкийн “хамгаалалтын” стратегийн шугамыг тодорхойлохдоо Алеулын арлууд, Япон, Рюкю болон Филиппиныг оруулж байснаас биш, Тайвань арлыг оруулж байгаагүй ажээ.

БНХАУ-ыг тунхагласны дараахан Бээжинд суугаа Америкийн консул Э.Клабб БНХАУ-ын Засгийн газар АНУ-тай дипломат харилцаа тогтооход бэлэн байгаа тухай Вашингтонд албан ёсоор мэдээлжээ. АНУ Конгресстой урьдчилан зөвлөхгүйгээр БНХАУ-ыг хүлээн зөвшөөрөхгүй гэж Төрийн департаментаас 1949 оны 10 дугаар сарын 3-нд албан ёсоор мэдэгдсэн байна. Удалгүй 10 дугаар сарын 12-нд Гадаад хэргийн Төрийн нарийн бичгийн дарга Д.Ачесон “Түлхэгдэн унаж, эх газрын Хятадаас гарсан гоминьданы дэглэмийнхнээс АНУ-ын өмнө хүлээсэн үүргийг нь оролцуулан олон улсын хэмжээнд түүний хүлээх үүрэг амлалтыг Ардын ардчилсан Засгийн газар хэрэв өөртөө нэр хүндтэйгээр хүлээн авах юм бол БНХАУ-ыг дипломат ёсоор хүлээн зөвшөөрч болох юм” гэжээ.

1950 оны 1 дүгээр сарын 10-нд Д.Ачесон Сенатын гадаад бодлогын асуудал эрхлэсэн хороонд үг хэлэхдээ: “Тайвань болон Өмнөд

Солонгосыг АНУ-ын стратегийн батлан хамгаалах ашиг сонирхлын хүрээнээс хассан”-аа мэдэгдсэн байна.

Америкийн Засаг захиргааныхны хийсэн иймэрхүү мэдэгдэл нь “коммунизмын өмнө буулт хийж байна” гэж АНУ-ын Засгийн газрыг шүүмжилж байсан өрнөдийнхний эрс эсэргүүцлийг төрүүлсэн юм. Сенатч Р.Тафт, Трумэны мэдэгдэл нь “Европт коммунизмыг тогтоон барих”-ын тулд авахаар тохиролцсон арга хэмжээтэй нийцэхгүй байна гэж мэдэгдсэн байхад “Хятадын асуудлыг” Сенатад дэмжихгүй байх талынхны төлөөлөгч У.Ноулэнд мэдэгдэхдээ: Засгийн газрын шийдвэр нь “Азид коммунизм дэлгэрэхэд тус дөхөм боллоо” гэж зэмлэж байжээ.

Солонгост дайн эхэлж, түүнд БНХАУ хөндлөнгөөс шууд оролцсон нь Хятадын талаарх АНУ-ын бодлогыг нэг мөр болгожээ.

Солонгост дайн эхэлсэнтэй холбогдуулан АНУ-ын ерөнхийлөгч Х.Трумэнээс 1950 оны 6 дугаар сарын 27-нд хийсэн мэдэгдэлдээ: “Формозыг чөлөөлөх ямар нэгэн түрэмгийлэл хийхийг саатуулж байх үүрэг”-ийг зэвсэгт хүчиндээ тушаажээ. “Номхон далайн аюулгүй байдлыг сэргээсний дараа, Японтой энх тайваны гэрээ байгуулсны дараа эсхүл НҮБ-аар хэлэлцсэний дараа Формозын ирээдүйн статусын тухай шийдвэр гаргах ёстой” гээд АНУ-ын Засгийн газар Тайванийг Хятадын нутаг дэвсгэр гэж үзэхээс татгалзаж байгаагаа албан ёсоор мэдэгджээ. Цаашилбал 1954 оны 12 дугаар сард АНУ-аас Тайвань дахь гоминьданы эрх баригчидтэй “харилцан хамгаалах” тухай гэрээ байгуулж, ингэснээрээ Тайваний талаар хүлээсэн үүргээ биелүүлэх “олон улсын хууль, эрх зүйн үндсийг” буй болгосон байна. Хэрэв БНХАУ-ын зэвсэгт хүчин Тайваньд цөмрөх тохиолдолд “цөмийн зэвсгээр хариу барина” гэж АНУ гэрээг шалтаглан “хүчээр түрээ” барих болсон байна. БНХАУ Тайвань болон Пэнхуледао арлыг чөлөөлөх ажиллагаагаа эхлэхээр зэхэж байна гэж АНУ-ын ерөнхийлөгчөөс үзэх юм бол арми, флотоо ашиглах онцгой бүрэн эрхийг түүнд Конгресс нь 1955 оны 1 дүгээр сард олгосон байна.

Тийнхүү Тайваний талаар баримтлах АНУ-ын бодлого үндсээрээ өөрчлөгдсөн нь үнэн хэрэг дээрээ коммунист Хятадын Солонгосын дайнд оролцсонтой шууд холбоотой байв.

ЗХУ, коммунист Хятадын шууд дэмжлэгтэйгээр Өмнөд Солонгост халдсан Хойд Солонгосын эзлэн түрэмгийллийг НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл 1950 оны 6 дугаар сарын 25-ны хуралдаанаар авч хэлэлцээд Умардыг 38 дугаар өргөргөөс хойш цэргээ нэн даруй эгүүлэн татахыг шаардаад, “Умард Солонгос нь дайн өдөөгч, түрэмгийлэгч улс” гэсэн тогтоол гаргасан байна. Улмаар Ий Сын-маны Засгийн газрыг цэрэг дайны үйл ажиллагаагаар дэмжихийг НҮБ-ын гишүүн улсуудад зөвлөмж болгосон 6 дугаар сарын 27-ны өдрийн тогтоол, НҮБ-ын цэргийн нэгдсэн командлалд зэвсэгт хүчин нийлүүлэхийг уриалсан 7

дугаар сарын 7-ны өдрийн уриалга, 1950 оны 10 дугаар сарын 25-нд Хятадын “сайн дурын арми” гэсэн нэртэй цэргийн хүчин НҮБ-ын нэгдсэн зэвсэгт хүчний эсрэг Солонгосын дайнд хөндлөнгөөс оролцсон тул НҮБ-ын Аюулгүй Зөвлөл Хятадыг цэргээ нэн даруй эгүүлэн татахыг шаардаад, “Хятад нь дайн өдөөгч, түрэмгийлэгч улс” гэсэн 10 дугаар сарын 26-ны өдрийн тогтоолуудыг тус тус гарсан юм.

Хятадын түрэмгийллийн улмаас АНУ 1950 оны 12 дугаар сард Хятадыг эдийн засгийн талаар ганцаардуулан тусгаарлах арга хэмжээ авахаа зарлаад америкийн хөлөг онгоцуудыг хятадын боомтуудад орохыг хориглож, АНУ дахь БНХАУ-ын актив, гүйлгээг хаасан байна. Стратегийн болон бусад бараа бүтээгдэхүүнийг Хятадад нийлүүлэх явдалд хориг тавих тухай Америкийн оруулсан тогтоолын төслийг НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1951 оны 5 дугаар сарын 18-нд баталжээ.

Ийнхүү АНУ-ын Чан Кайшигийн Тайванийг дэмжсэн “нэг Тайвань, нэг Хятад” хэмээх “хоёр хятад”-ын бодлогын эхлэл тавигдаж, Америк-Хятадын 20 илүү жил үргэжилсэн хүйтэн дайны сөргөлдөөнийн үүд нээгдсэнээс гадна, ЗХУ, БНХАУ-ын шууд оролцоотой Солонгосын дайнд БНМАУ Хойд Солонгосын талд баттай зогсч, үүний хаялга НҮБ-д элсэх Монгол Улсын хүчин чармайлтыг олон жил хойш нь татахад нөлөөлсөн байна.

БНХАУ Солонгосын дайнд хөндлөнгөөс шууд оролцсон нь Хятадыг ч НҮБ-д гишүүнээр элсэхийг, түүнчлэн Хятад, Америкийн харилцааг хэвийн болгох үйл явцыг олон жилээр хойш татах нэг том шалтгаан болжээ.

Солонгосын дайны төгсгөл: Кэсонь-Пань Мынь-жом-Женев

1951 оны 7 дугаар сарын 10-нд гал зогсоох асуудлаарх хэлэлцээ 38 дугаар өргөргийн ойролцоох Кэсонь хотод эхэлж, нэг талаас БНАСАУ, Хятадын “сайн дурын армийн” төлөөлөгчид, нөгөө талаас НҮБ-ын нэгдсэн зэвсэгт хүчнийг төлөөлж АНУ болон Өмнөд Солонгосын төлөөлөгчид оролцжээ. Хэлэлцээний явцад хоёр тал бие биенээ буруутгаж, өөр өөрсдийн болзол, нөхцлийг тулган хэлэлцээ сунжирсан юм. Хэлэлцээ мухардалд орсон гол шалтгаан нь хөшигний ард байсан хариуцлагатай зөвлөх И.В.Сталин, Мао Зедун түүнчлэн Ким Ил-соноос шалтгаалж байсан нь өнөөдөр тодорхой болов.

Энэтхэг улсын ерөнхий сайд Ж.Неру 1950 оны 7 дугаар сарын 13-нд ЗХУ, АНУ-ын Засгийн газарт илгээсэн уриалгадаа БНХАУ-ыг оролцуулан хэлэлцээ хийх замаар Солонгосын хойг дэх дайны ажиллагааг зогсоох санал тавьж, үүнд Энэтхэг улс зуучлахад бэлэн байгаагаа илэрхийлжээ. Энэтхэг улс хэлэлцээ сунжирахад ЗХУ, БНХАУ болон социалист орнуудаас нэг талын буулт хийхийг шаргуу шаардсан байна.

Дэлхийн II дайнд Германы фашизмыг ялсан ЗХУ, ялангуяа Сталин өөрийнхөө асар их нэр хүндийг ашиглан Солонгосын дайны

жинхэнэ учир шалтгааны талаар дэлхий нийтийг асар их төөрөгдүүлж байсан ажээ. Тиймээс Европ, Америкт Солонгосын дайныг эсэргүүцсэн хөдөлгөөн эрчимтэй өрнөсөн юм.

Дэлхийн олон нийтийн шахалт шаардлагаар дайнд оролцогч талууд 1953 оны 4 дүгээр сарын 26-нд хэлэлцээг Пань Мынь-жомд сэргээжээ. Мэдээж Сталин 3 дугаар сарын 5-нд таалал төгссөн нь гол учир шалтгаан байв. Цэргийн олзлогдогсдыг нутагт нь буцаах тухай хэлэлцээрт Энэтхэгийн зуучлалаар 7 дугаар сарын 8-нд гарын үсэг зурав. Асуудлыг энх тайвнаар төгс зохицуулах хүртэл “Солонгос дахь дайн болон дайсагнасан аливаа явдлыг бүрэн зогсоохоор” заасан Солонгосын хойгт гал зогсоох тухай хэлэлцээрт 1953 оны 7 дугаар сарын 27-нд гарын үсэг зурав. Уг хэлэлцээрээр заагласан зурвас, цэрэг, зэвсэггүй бүс тодорхойлон тогтоож, гал зогсоосон бүхий л үеийн туршид нэмэгдэл хүч, зэр зэвсгийг Солонгост оруулахыг хориглон, дайн зогсоох хоёр талын цэргийн комисс болон дайн зогсоож байгаа байдлыг ажиглан хянах Польш, Чехословак, Швед, Швейцарийн төлөөлөгчдөөс бүрдсэн олон улсын комиссийн үүргийг тодорхойлсноос гадна цэргийн олзлогдогсдыг эх оронд нь буцаах болзлыг бас дурджээ. Гадаадын зэвсэгт хүчнийг Солонгосоос гаргаж, солонгосын асуудлыг энх тайвнаар бүхэлд нь зохицуулах тухай асуудлыг шийдвэрлэхийн тулд олон улсын бага хурал хуралдуулахаар хэлэлцээрт заажээ.

Дайн зогсоох тухай хэлэлцээрийг цаашид улам баталгаажуулах зорилгоор АНУ, Англи, Франц, ЗХУ, БНХАУ, БНАСАУ, Өмнөд Солонгос, Энэтхэг, Польш, Чехословак, Индонез, Египет, Сири, Мексик болон Бирмийг оролцуулсан улс төрийн зөвлөлгөөн хуралдуулах саналыг Зөвлөлтийн төлөөлөгч 1953 оны 8 дугаар сард НҮБ-ын Ерөнхий Ассамблейн VII чуулганд оруулжээ. Харин АНУ зөвхөн байлдсан улсуудыг оруулахаар зөвлөлгөөний бүрэлдэхүүнийг сонгох санал гаргасан нь олонхийн санал авч тогтоол батлагджээ.

Солонгосыг нэгтгэх, Вьетнамд энх тайван байдал тогтоох, НҮБ дэх БНХАУ-ын эрхийн тухай болон Тайваний асуудлыг авч хэлэлцүүлэхийн тулд таван их гүрний ГЯЯ-ны сайд нарын бага хурал хуралдуулах саналыг АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга А.Даллес гаргасан бөгөөд уулзалтад оролцогчид АНУ, ЗХУ, Англи, Франц, БНХАУ-ын төлөөлөгчдийн бага хурлыг 1954 оны 4 дүгээр сарын 26-нд Женев хотноо хуралдуулахаар зөвшилцсөн байна.

Олон улсын байдал нарийн түвэгтэй байсан боловч бага хурал товлосон хугацаандаа эхэлжээ. Бага хуралд таван гүрний төлөөлөгчдөөс гадна БНАСАУ, Өмнөд Солонгос, Солонгосын дайнд НҮБ-ын Нэгдсэн зэвсэгт хүчинд цэргээ илгээсэн 12 орны төлөөлөгчид оролцов. Гэвч бага хуралд оролцогч талууд өөр өөрсдийн хэлэлцээрийн төсөл, саналыг нотлохыг хичээж байснаас Солонгосын

нэгдлийг сэргээх асуудлаар нэгдсэн ойлголтод хүрч чадалгүй Женевийн хурал мухардалд орж, тиймээс ч гал зогсоох 1953 оны 7 дугаар сарын 27-ны хэлэлцээр нь Умард, Өмнөдийн харилцааны эрх зүйг тодорхойлсон үндсэн баримт бичиг болж XXI зуунтай золгосон байна.

НОМ ЗҮЙ

1. The Cold War In Asia. Cold war international history project, Woodrow Wilson International Center for Scholars, Washington, D.C. “*BULLETIN*”, Issues 6-78 Winter 1995-1996
2. Chen Jian, China’s Road to the Korean War: The Making of the Sino-American Confrontation, New York: Columbia University Press, 1994
3. Bruce Cumings, The Origins of the Korean War, vol. 2, 1990
4. Kim Hak Joon, Korea’s Relations with her neighbors in a Changing World, Hollym International Corp. 1995
5. Henry Kissinger, Diplomacy, Simon and Schuster, 1994
6. Allen S. Whiting, China Crosses the Yalu: The Decision to Enter the Korean War, New York: Macmillan, 1960
7. Department of State, Bulletin, January 16, 1050, vкл. 22, №550
8. K.M.Panikkar, In two China. The Memories of a Diplomat, London., 1955
9. China and US Far East Policy, 1945-1967. Washington D.C, 1968
10. G. Lawrence, H.Ballistini, The Sino-American Confrontation a look at the Chinese side, The Yale Review, vol. 58, 1968
11. International Affairs, January 1950
12. E.Luard, Great Britain and China. London., 1962
13. Внешняя политика и международные отношения КНР, (1949-1963) том I, М., 1975